



“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК
Дархан-Уул аймаг, Дархан сум, 16-р баг,
Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХХК,
206 тоот өрөө
Утас/факс: 7509-0044
Вэбсайт: www.dmp.mn

“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК-д шаардлагатай
шууд худалдан авалтын зар **№221**

Тендер шалгаруулалтын дугаар: **ДААТҮТӨХК/20260601552**
Төсөвт өртөг: **6,912,500 төгрөг**

2026.09.08

№	Бараа ажил, үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үзүүлэлт
1	Усны нөөцийн савны ариутгал, халдваргүйтгэл	цогц	1.0	Ариутгал халдваргүйтгэл хийх эрх бүхий мэргэжлийн байгууллага байх

Усны нөөцийн савны ариутгал халдваргүйтгэл, шинжилгээ хийлгэх ажлын даалгавар.

1	Захиалагч байгууллага	“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК
2	Захиалагч байгууллагын хаяг	Үйлдвэрийн район, Хонгор сум, Дархан-Уул аймаг, Монгол улс
3	Байршил	1. Дархан-Уул аймаг, Хонгор сум, Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК-ийн Гангийн үйлдвэр 2. Сэлэнгэ аймаг, Хүдэр сум, Төмөртэй уурхай 3. Сэлэнгэ аймаг, Хүдэр сум, Төмөртэй өртөө 4. Дархан-Уул аймаг, Хонгор сум, Төмөртолгой уурхай
4	Зорилго	- Усны чанар, аюулгүй байдлыг хангах - Ундны усанд нянгийн бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлэх - Усны нөөцийн сав, дамжуулах шугам хоолойн ариутгал халдваргүйтгэл хийлгэх - MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ стандартын шаардлага хангах
5	Гүйцэтгэгч байгууллагад тавигдах шаардлага	- Итгэмжлэл бүхий лабораторитой байх. - Ариутгалд ашиглах бодис нь Монгол улсад зөвшөөрөгдсөн, стандартын шаардлага хангасан байх. - Мэргэжлийн нян судлаач, лаборанттай байх.
6	Хийгдэх ажил	Усны нөөцийн савны ариутгал, халдваргүйтгэл: - Усны нөөцийн савны дотор болон гадна үзлэг хийж бохирдлын түвшинг тогтоох. - Савны тунадас, лаг, хаг, өнгөр болон бусад бохирдлыг механик аргаар бүрэн цэвэрлэх.

		- Монгол Улсад хэрэглэхийг зөвшөөрсөн ариутгал, халдваргүйтгэлийн бодис ашиглан ариутгал хийх. - Ариутгалын бодисын найрлага, тун хэмжээ, үйлчлэх хугацааг үйлдвэрлэгчийн заавар болон холбогдох стандартын дагуу мөрдөх. - Ариутгалын дараа савыг цэвэр усаар зайлан ашиглалтад бэлэн болгох. Ус дамжуулах шугамын ариутгал, халдваргүйтгэл: - Ус дамжуулах шугам хоолойд халдваргүйтгэл хийх. - Шугам сүлжээг ариутгалын уусмалаар дүүргэн шаардлагатай хугацаанд байлгах. - Ариутгалын дараа үлдэгдэл ариутгалын бодисыг бүрэн зайлуулах хүртэл угаалт хийх. Усны шинжилгээ: - Ундны усны шинжилгээг улирал тутам хими болон нян судлалын үзүүлэлтээр шинжилгээ хийж шинжилгээний үр дүнг хүргүүлнэ.
7	Ажил гүйцэтгэх хугацаа	Усны шинжилгээ: Улирал тутам - Гангийн үйлдвэр 3 дээж - Төмөртолгой уурхай 3 дээж - Төмөртэй уурхай 3 дээж - Төмөртэй өртөө 2 дээж шинжилнэ. Ариутгал халдваргүйтгэл: - Ажлыг захиалагчтай харилцан тохиролцсон хугацаанд хийж гүйцэтгэнэ.
8	Тайлан	- Ариутгал, халдваргүйтгэлийн ажлын акт. - Усны шинжилгээний лабораторийн албан ёсны дүгнэлт. - Ашигласан ариутгалын бодисын нэр, үйлдвэрлэгч, хэрэглэсэн хэмжээ. - Ариутгалын өмнөх болон дараах фото зураг.

Жич:

- Урьдчилгаа төлбөр олгохгүй
- Төлбөрийг ажил гүйцэтгэсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор төлнө.

Бүрдүүлж ирүүлэх материал:

- Албан бичиг /Үнийн санал, ажил гүйцэтгэх хугацаа, төлбөрийн нөхцөлийг дурдсан байх/
- Байгууллагын гэрчилгээ, НӨАТ-ын гэрчилгээ
- Ажлын даалгавар, танилцуулга, бусад нотлох баримт
- Хариуцах этгээдийн итгэмжлэл, холбогдох мэйл, утасны дугаар

Үнийн санал хүлээн авах сүүлийн хугацаа:
2026 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 17 цаг 00 минут хүртэл

Шууд худалдан авалттай холбоотой тодруулга
болон үнийн санал хүлээн авах хаяг:
Худалдан авалтын хэлтэс
/procurement@dmp.mn/
Утас: 7509-0044